ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2022/69/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг
Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ ........ 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

3.Аудитын тайлан ........ 9

3.1 Ерөнхий зүйл ........ 9

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино ........ 10

3.4 Материаллаг байдал ........ 10

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 11

3.8 Аудитын гол асуудал ........ 11

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 11

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 11

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 12

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол ........ 12

4. Аудитын илрүүлэлт ........ 12

4.1 Залруулсан алдаа ........ 12

4.2 Зөвлөмж ........ 12

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ 13

## 1.Аудитын гэрчилгээ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.21 № 44

танай ______-ны №______-т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА О.ХИШИГСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

0150???

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 16,838,855.00 | 26,374,885.00 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | (0.00) | 0.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | (0.00) | 0.00 |
| 3121 | Төгрөг | (0.00) | 0.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | (0.00) | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 16,838,855.00 | 26,374,885.00 |
| 354 | Хангамжийн материал | 16,838,855.00 | 26,374,885.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,646,550.00 | 4,324,560.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,184,305.00 | 13,321,325.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 3,008,000.00 | 8,219,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 510,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 569,564,840.76 | 594,271,190.06 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 569,564,840.76 | 594,271,190.06 |
| 392 | Биет хөрөнгө | 549,976,090.77 | 574,862,440.07 |
| 39201 | Барилга, байгууламж | 435,909,522.95 | 435,909,522.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,891,923.44) | (22,337,885.16) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 45,600,000.00 | 107,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (17,783,333.39) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 90,856,434.40 | 105,585,749.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (33,759,110.19) | (57,469,803.65) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,468,683.99 | 50,452,298.99 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,980,185.10) | (35,471,855.83) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,430,341.58 | 10,430,341.58 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,718,173.42) | (2,308,926.82) |
| 39217 | Номын фонд | 60,500.00 | 256,332.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 19,588,749.99 | 19,408,749.99 |
| 39301 | Програм хангамж | 720,000.00 | 720,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (31,250.01) | (211,250.01) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,900,000.00 | 18,900,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 586,403,695.76 | 620,646,075.06 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 0.00 | 98,510.42 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 98,510.42 |
| 413 | Өглөг | 0.00 | 98,510.42 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.00 | 98,510.42 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 586,403,695.76 | 620,547,564.64 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 586,403,695.76 | 620,547,564.64 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 679,845,393.20 | 679,845,393.20 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 679,845,393.20 | 679,845,393.20 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (95,527,732.44) | (61,383,863.56) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (95,527,732.44) | (95,527,732.44) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 34,143,868.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,086,035.00 | 2,086,035.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 586,403,695.76 | 620,646,075.06 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 635,639,545.64 | 590,530,990.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 90,097,745.64 | 73,919,190.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 90,097,745.64 | 73,919,190.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | 12,957,777.00 | 73,280,462.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал | 478,960.00 | 638,728.00 |
| 120009 | Бусад орлого | 76,661,008.64 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 545,541,800.00 | 516,611,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 545,541,800.00 | 512,356,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 545,541,800.00 | 512,356,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 4,255,000.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө | - | 4,255,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 572,602,779.73 | 556,387,121.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 572,602,779.73 | 556,387,121.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 537,788,451.28 | 551,056,117.69 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 381,016,631.00 | 383,928,784.03 |
| 210101 | Цалин | 302,372,531.00 | 299,194,066.02 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 51,629,600.00 | 52,046,239.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,480,800.00 | 15,043,804.35 |
| 210104 | Урамшуулал | 10,533,700.00 | 17,644,674.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,282,040.55 | 49,714,085.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 32,652,140.55 | 34,454,061.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,907,500.00 | 3,841,595.22 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 3,126,000.00 | 3,073,296.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 781,500.00 | 757,152.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 7,814,900.00 | 7,587,980.71 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,984,600.00 | 12,711,582.54 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,375,500.00 | 6,596,392.54 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 9,879,900.00 | 4,771,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,729,200.00 | 1,344,090.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 42,693,960.00 | 30,666,452.76 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 15,299,660.00 | 7,567,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,338,000.00 | 7,663,000.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 10,286,300.00 | 7,714,094.76 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1,020,000.00 | 1,656,040.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 7,750,000.00 | 6,066,268.00 |
| 2105 | Нормативт зардал | 500,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 450,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,000,000.00 | 12,672,580.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 3,000,000.00 | 2,692,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,600,000.00 | 9,979,980.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,693,500.00 | 1,672,500.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 5,693,500.00 | 1,672,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 5,702,400.00 | 2,037,720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,732,800.00 | 479,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 432,500.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 1,222,000.00 | 1,222,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,800.00 | 128,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 150,800.00 | 150,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,500.00 | 57,120.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,915,319.73 | 57,202,412.70 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,915,319.73 | 57,202,412.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,814,328.45 | 5,331,003.43 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,338,000.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,838,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 2,500,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,476,328.45 | 4,331,003.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,476,328.45 | 4,331,003.43 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт | | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 63,036,765.91 | 34,143,868.88 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 63,036,765.91 | 34,143,868.88 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 545,541,800.00 | 516,611,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 545,541,800.00 | 516,611,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 545,541,800.00 | 512,356,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 545,541,800.00 | 512,356,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 4,255,000.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 4,255,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 545,541,800.00 | 507,983,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 545,541,800.00 | 507,983,500.00 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 510,727,471.55 | 502,652,496.57 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 381,016,631.00 | 383,928,784.03 |
| 210101 | Үндсэн цалин | 302,372,531.00 | 299,194,066.02 |
| 210102 | Нэмэгдэл | 51,629,600.00 | 52,046,239.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,480,800.00 | 15,043,804.35 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 10,533,700.00 | 17,644,674.60 |
| 2102 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,282,040.55 | 49,615,575.24 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 32,652,140.55 | 34,355,550.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,907,500.00 | 3,841,595.22 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 3,126,000.00 | 3,073,296.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 781,500.00 | 757,152.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 7,814,900.00 | 7,587,980.71 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 15,774,600.00 | 15,351,582.54 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,375,500.00 | 6,596,392.54 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 8,669,900.00 | 7,411,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,729,200.00 | 1,344,090.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 42,758,300.00 | 32,288,194.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,106,500.00 | 7,947,460.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,249,000.00 | 10,068,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,286,300.00 | 7,714,094.76 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,020,000.00 | 1,656,040.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,096,500.00 | 4,902,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 500,000.00 | 450,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 450,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,000,000.00 | 17,308,140.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 3,000,000.00 | 5,670,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 11,637,440.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,693,500.00 | 1,672,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,693,500.00 | 1,672,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,702,400.00 | 2,037,720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураам | 3,732,800.00 | 479,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,500.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,222,000.00 | 1,222,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,800.00 | 128,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150,800.00 | 150,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 35,500.00 | 57,120.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,814,328.45 | 5,331,003.43 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,338,000.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,838,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 2,500,000.00 | 1,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,476,328.45 | 4,331,003.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,476,328.45 | 4,331,003.43 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | 8,628,300.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 8,628,300.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 8,628,300.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 8,628,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 8,628,300.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V | - | (8,628,300.00) |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | (0.00) | (0.00) |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | (0.00) | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -158564498.35 | 523366929.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -158564498.35 | 523366929.85 |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0.00 | 63036765.91 | 63036765.91 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -95527732.44 | 586403695.76 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -95527732.44 | 586403695.76 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -95527732.44 | 586403695.76 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, буурал | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0.00 | 0.00 | 34143868.88 | 34143868.88 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 679845393.20 | 2086035.00 | -61383863.56 | 620547564.64 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) | 0.00 | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 512.356.800.00 | 508.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 512.356.800.00 | 508.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 511.356.800.00 | 507.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 384.024.200.00 | 383.928.784.03 | 95.415.97 | 99.98 |
| 210101 | Үндсэн цалин | 305.380.100.00 | 299.194.066.02 | 6.186.033.98 | 97.97 |
| 210102 | Нэмэгдэл | 51.629.600.00 | 52.046.239.06 | (416.639.06) | 100.81 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 16.480.800.00 | 15.043.804.35 | 1.436.995.65 | 91.28 |
| 210104 | Урамшуулал | 10.533.700.00 | 17.644.674.60 | (7.110.974.60) | 167.51 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50.750.800.00 | 49.615.575.24 | 1.135.224.76 | 97.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36.120.900.00 | 34.355.550.85 | 1.765.349.15 | 95.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3.707.500.00 | 3.841.595.22 | (134.095.22) | 103.62 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3.126.000.00 | 3.073.296.10 | 52.703.90 | 98.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 781.500.00 | 757.152.36 | 24.347.64 | 96.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7.014.900.00 | 7.587.980.71 | (573.080.71) | 108.17 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15.374.600.00 | 15.351.582.54 | 23.017.46 | 99.85 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 7.375.500.00 | 6.596.392.54 | 779.107.46 | 89.44 |
| 210302 | Түлш, халаалт | 6.669.900.00 | 7.411.100.00 | (741.200.00) | 111.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1.329.200.00 | 1.344.090.00 | (14.890.00) | 101.12 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 32.288.300.00 | 32.288.194.76 | 105.24 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5.014.000.00 | 7.947.460.00 | (2.933.460.00) | 158.51 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 10.068.000.00 | 10.068.000.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 11.286.300.00 | 7.714.094.76 | 3.572.205.24 | 68.35 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1.020.000.00 | 1.656.040.00 | (636.040.00) | 162.36 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 4.900.000.00 | 4.902.600.00 | (2.600.00) | 100.05 |
| 2105 | Нормативт зардал | 500.000.00 | 450.000.00 | 50.000.00 | 90.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 500.000.00 | 450.000.00 | 50.000.00 | 90.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 21.700.000.00 | 21.681.440.00 | 18.560.00 | 99.91 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11.500.000.00 | 11.493.000.00 | 7.000.00 | 99.94 |
| 210604 | Урсгал засвар | 10.200.000.00 | 10.188.440.00 | 11.560.00 | 99.89 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2.393.500.00 | 1.672.500.00 | 721.000.00 | 69.88 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2.393.500.00 | 1.672.500.00 | 721.000.00 | 69.88 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4.325.400.00 | 2.037.720.00 | 2.287.680.00 | 47.11 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2.332.800.00 | 479.000.00 | 1.853.800.00 | 20.53 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 432.500.00 | - | 432.500.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1.222.000.00 | 1.222.000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128.800.00 | 128.800.00 | - | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 150.800.00 | 150.800.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 58.500.00 | 57.120.00 | 1.380.00 | 97.64 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1.000.000.00 | 1.000.000.00 | 0.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1.000.000.00 | 1.000.000.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1.000.000.00 | 1.000.000.00 | - | 100.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | (0.00) | 0.00 | - |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | (0.00) | 0.00 | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 512.356.800.00 | 508.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 512.356.800.00 | 508.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 512.356.800.00 | 508.025.796.57 | 4.331.003.43 | 99.15 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) | 0.00 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 4,255,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 4,255,000.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | - | 4,255,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | - | 4,255,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,610,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 2,645,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 4,255,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 4,255,000.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө | - | 4,255,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.01.19-нөөс 2022.01.21–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.01.21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.17-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн Тамгын газар нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй.

2021 онд ШЕЗ-ийн даргын албан даалгаврыг хангаж биелүүлэх, шүүн таслах ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй болгох, шударга ёсыг бэхжүүлэх, шүүгч, ажилтнуудынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах тэргүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 556.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газрын 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 81.6 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 8.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 72.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авчээ. Тайлант онд үндсэн хөрөнгө данснаас хасаагүй байна.

Бараа материалын тодруулга тайлангаар 49.6 сая төгрөгийн бараа материал орлого авснаас 48.9 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр, 0.6 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 40.1 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 4.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 512.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүцэтгэлээр 508.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 4.2 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 510.0 сая төгрөгийн 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 509.0 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Өмч хөрөнгийг зарцуулах

977.8 мянган төгрөгийн 3 шийдвэрийг шилэн дансны сайтад байршуулаагүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Иймд дээрх зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажиллалаа.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллын 2020 оны санхүүгийн тайланд Шилэн дансны хуулийн хэрэгжилт, зардал хооронд шилжүүлэн зарцуулсантай холбоотой 19.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 05.28-нд №112 тоот албан бичгээр ирүүлсэн. Тайлант онд энэхүү зөрчлийг давтан гаргаагүй байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар дотоод хяналт хангалтгүй байснаас 0.3 төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй алдаа илэрч аудитын явцад хөрөнгийг бүртгэлд тусгуулсан. Хөрөнгийг бүртгэлд тусгаснаар бүртгэлээр тавих хяналт сайжирч, хөрөнгийн ашиглалт, үр өгөөж нэмэгдэнэ гэж үзэж, үр өгөөж тооцож хүлээн зөвшөөрүүллээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар дотоод хяналт хангалтгүй байснаас 0.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй алдаа илэрч аудитын явцад хөрөнгийг бүртгэлд тусгуулсан.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Эд хариуцагчийн тайлан, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах талаар.**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Эд хариуцагчийн тайланг сар бүр тогтмол гаргадаггүй, шаардах хуудасны бичилт, цохолтыг бүрэн хийгээгүй, гарын үсгийн бүрдүүлэлт хангалтгүй, нүүрс зарцуулалтыг өдөр тутамд зарцуулсан, хяналт тавьсан анхан шатны баримт хангалтгүй байсан зэрэг зөрчлүүд байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно. 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. <u>Эрсдэл:</u>

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

<u>1.3. Өгсөн зөвлөмж:</u>

**Зөвлөмж-1**. Байгууллагын удирдлагын зүгээс хөрөнгийн зарцуулалтад тавих өдөр тутмын хяналтыг сайжруулах.
**Зөвлөмж-2**. Зөрчлөөр дурдагдсан анхан шатны баримтуудыг зохих шаардлагын түвшинд хангаж ажиллах, Эд хариуцагчийн тайланг сар бүр гаргуулж хянаж, хүлээж авах.

<u>1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

**2. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар.**

1.1. Илрүүлэлт:

Дараа оны төсвийн төслийг ил тод мэдээлээгүй, Өмч хөрөнгийг зарцуулах 977.8 мянган төгрөгийн 3 шийдвэрийг шилэн дансны сайтад байршуулаагүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

**Зөвлөмж-3**. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.3, 6.4.8-д заасан заалтуудыг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх 3 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 06 дугаар сарын 01-ний** өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар | 4 | 1.3 | 1 | 0.3 | | | | | 3 | 0.1 |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт**

**Аудитын нэр:** Санхүүгийн тайлангийн аудит **Аудитын код:** ӨВА-2022/96/НА-СТА-ТШЗ

**Байгууллагын нэр:** Хархорин сум дахь Сум дундын шүүх

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /сая/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын Албан тушаал | Шалгагдагч байгууллагын Овог нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **A** | **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** | **8** | **9** |
| 1 | Бараа материал | Эд хариуцагчийн тайланг сар бүр тогтмол гаргадаггүй, шаардах хуудасны бичилт, цохолтыг бүрэн хийгээгүй, гарын үсгийн бүрдүүлэлт хангалтгүй, нүүрс зарцуулалтыг өдөр тутамд зарцуулсан, хяналт тавьсан анхан шатны баримт хангалтгүй байсан зэрэг зөрчлүүд байна. | 0 | Зөвлөмж өгөх | Санал байхгүй. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно. 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. | **Зөвлөмж-1**. Байгууллагын удирдлагын зүгээс хөрөнгийн зарцуулалтад тавих өдөр тутмын хяналтыг сайжруулах. **Зөвлөмж-2**. Зөрчлөөр дурдагдсан анхан шатны баримтуудыг зохих шаардлагын түвшинд хангаж ажиллах, Эд хариуцагчийн тайланг сар бүр гаргуулж хянаж, хүлээж авах. | Дарга, Нягтлан бодогч | О.Хишигсүрэн, Б.Батмөнх |
| 2 | Шилэн данс | Дараа оны төсвийн төслийг ил тод мэдээлээгүй, Өмч хөрөнгийг зарцуулах 977.8 мянган төгрөгийн 3 шийдвэрийг шилэн дансны сайтад байршуулаагүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. | 1 | Зөвлөмж өгөх | Санал байхгүй. | Шилэн дансны тухай хуулийн 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. | **Зөвлөмж-1**.Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1.3, 6.4.8-д заасан заалтуудыг хэрэгжүүлж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах. | Дарга, Нягтлан бодогч | О.Хишигсүрэн, Б.Батмөнх |

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА О.ХИШИГСҮРЭН

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Б.БАТМӨНХ

ЙРГОО
i045147 6215 10